



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/55.

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 09 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу шуурхай зохион байгуулж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

4. Эрх шилжүүлсэн барилга, засвар, тохижилтын төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг сумдын Засаг даргын Тамгын газартэй хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/-д хариуцуулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг /сая ₮/	Эрх шилжүүлсэн захиалагч
1.	Дадал сум ЗДТГ автомашин	2019 он	40,0	Дадал сумын Засаг даргын Тамгын газар
2.	Бор-Өндөр сум ЗДТГ автомашин	2019 он	50,0	Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар
3.	Хэрлэн сумын 5-р багт тоглоомын талбай	2019 он	30,0	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар
4.	Хэрлэн сумын нийтийн тээврийн автограж, хашаа	2019 он	60,0	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар
5.	Хэрлэн сумын "Төв цэцэрлэг, ногоон байгууламж"-ийн тохижилт, гэрэлтүүлэг	2019 он	50,0	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар
	НИЙТ ДҮН		230,0	